



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/229

Мандалговь

“Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн  
комиссыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1 дэх, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 23-ны А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 1.5, 1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

Комиссын дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал

хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын эм, эмнэлгийн

хэрэгслийн хангамж, тусгай зөвшөөрөл, ёс зүй хариуцсан мэргэжилтэн

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журмыг мөрдлөг болгон удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/351 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822100380